



SheVotes: Mongolia

ЭМЭГТЭЙЧҮҮД, ЗАЛУУЧУУДЫН УЛС ТӨРИЙН
ОРОЛЦООНД ТУЛГАРЧ БУЙ СААД
БЭРХШЭЭЛҮҮДИЙН ТУХАЙ

SheVotes: Mongolia


Эмэгтэйчүүд, залуучуудын улс төрийн оролцоонд тулгарч буй саад бэрхшээлүүдийн тухай

Зохиогчийн эрх © 2021 Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн. Зохиогчийн эрх хуулийн дагуухамгаалагдсан болно.

Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэнгээс бичгээр зөвшөөрөл аваагүй тохиолдолд бүтээлийг бүтнээр болон хэсэгчлэн хувилах, нийтлэх, электрон системд оруулах болон бусад ямар нэг хэлбэрээр олшруулахыг хориглоно.

Зөвшөөрөл авах хүсэлтэд дараах мэдээлэл шаардлагатай:

- Ашиглах зөвшөөрөл хүсэж буй бүтээлийн нэр, сэдэв
- Ашиглах зөвшөөрөл хүсэж буй материалын агуулга
- Бүтээлийг ашиглах зорилго, хэрхэн ашиглагдах талаарх мэдээлэл
- Таны нэр, албан тушаал, байгууллагын нэр, утасны дугаар, факс, цахим хаяг, шуудангийн хаяг



Бүтээлийг ашиглах зөвшөөрөл хүссэн мэдээллээ доорх хаягаар явуулна уу:

Attention Communications
Department International
Republican Institute
1225 Eye Street NW, Suite 800
Washington,
DC 20005
info@iri.org

Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэнгийн тухай

1983 оноос хойш Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн (БНОУХ) нь ил тод, хариуцлагатай засаглалыг хөгжүүлж, улс төрийн намуудын эгэх хариуцлагыг нэмэгдүүлж, нийгмийн эмзэг бүлгүүдийн, тэр дундаа эмэгтэйчүүд, залуучуудын улс төрийн үйл явц дахь үүрэг оролцоог дээшлүүлэх замаар дэлхий дахинаа эрх чөлөө, ардчиллыг бэхжүүлэх зорилготой үйл ажиллагаа явуулж буй ашгийн төлөө бус, нам бус байгууллага юм.

Монгол дахь БНОУХ

БНОУХ нь 1992 оноос хойш Монгол улсад тасралтгүй үйл ажиллагаа явуулж байна. БНОУХ-ийн Монгол дахь салбар нь нам бус үйл ажиллагаагаараа дамжуулан улс төрийн намууд болон иргэний нийгмийн байгууллагуудтай үндэсний болон орон нутгийн түвшинд хамтран ажиллаж байна. Хамгийн сүүлд АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагаас (USAID) санхүүжилттэй Монгол дахь залуучууд, эмэгтэйчүүдийн сонгууль, улс төрийн оролцоог идэвхжүүлэх нь (SWYEEPPM) хөтөлбөрөөр дамжуулан иргэний нийгмийн байгууллагуудыг чадавхжуулах, эгэх хариуцлагатай засаглалыг дэмжих, улс төрийн хариуцлагыг бий болгохоор эмэгтэйчүүд, залуучуудад төвлөрөн ажиллаж байна.

Эдүкэйтэд Энтерпрайз

Эдүкэйтэд Энтерпрайз ХХК нь аль ч салбарын хувь хүн, байгууллагыг өөрсдийн нийгмийнхээ тогтвортой, хүртээмжтэй өсөлт, хөгжилд хувь нэмэр оруулагч идэвхтэй, чадвартай бүрдэл болоход нь туслан, чиглүүлэгч нийгмийн энтерпрайз юм. Бид нийгмийн инновац, нийгмийн энтерпрайзийг суурь болгосон чанарын судалгаа, судалгаанд суурилсан шийдлийн загварчлал буюу зөвлөх үйлчилгээ, шийдэлд суурилсан сургалт, чадавхжуулах үйл ажиллагаа, зорилтот контент хөгжүүлэлт зэрэг үндсэн чиглэлүүдээр үйл ажиллагаа эрхэлдэг. Бидний үйл ажиллагааны үндсэн зорилтот бүлгүүдэд залуучууд болон эмэгтэйчүүд ордог.

Талархал

Энэхүү судалгааг АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн тусламжтайгаар Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэнгийн хэрэгжүүлж буй “Залуучууд, эмэгтэйчүүдийн сонгууль, улс төрийн оролцоог идэвхжүүлэх нь” хөтөлбөрийн хүрээнд хийв.

Мэдэгдэл

Судалгааны тайланд илэрхийлэгдсэн агуулга нь судалгаанд оролцсон хувь хүмүүсийн үзэл санаа бөгөөд АНУ-ын засгийн газар эсхүл дээрх агентлаг, хүрээлэнгийн албан ёсны байр суурь биш болно. Мөн энэхүү тайланд ашиглагдсан зургуудад орсон хүмүүс нь дээр дурдсан агентлаг, хүрээлэн болон судалгааны оролцогчидтой хамааралгүй болно.



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Гарчиг

Товчилсон үгийн жагсаалт	6
Ерөнхий тойм	7
Үндсэн дүгнэлт	8
Судалгааны арга зүй	10
Судалгаанд оролцогчдын мэдээлэл	12
Агуулгын товч	14
Дүгнэлт шинжилгээ	16
Дүгнэлт 1	16
Дүгнэлт 2	16
Дүгнэлт 3	16
Дүгнэлт 4	16
Дүгнэлт 5	16
Дүгнэлт 6	16
Дүгнэлт 7	22
Зөвлөмж	24
Хавсралтууд	27

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АН	Ардчилсан нам
АНСДИТХСТХ	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль
БНОУХ	Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн
ГЯ	Ганцаарчилсан ярилцлага
ДЭЗФ	Дэлхийн эдийн засгийн форум
ЗГ	Засгийн газар
ИЗНН	Иргэний зориг ногоон нам
ИН	Иргэний нийгэм
ИТХ	Иргэдийн төлөөлөгчийн хурал
МАА	Мал аж ахуй
МАН	Монгол ардын нам
МУИХСТХ	Монгол улсын их хурлын сонгуулийн тухай хууль
МУҮХ	Монгол улсын Үндсэн хууль
НҮБХХ	Нэгдсэн үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөр
ОУБ	Олон улсын байгууллага
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
Сонгуулийн тухай хууль	МУИХСТХ болон АНСДИХСТХ-иуд
ТББ	Төрийн бус байгууллага
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилгууд
УИХ	Монгол улсын Улсын их хурал
УТНТХ	Улс төрийн намын тухай хууль
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ФБЯ	Фокус бүлгийн ярилцлага
ХЗДХЯ	Хууль зүй дотоод хэргийн яам
ХҮН	Хөдөлмөрийн үндэсний нам
ЭАС	Эмэгтэйчүүдийн ардчиллын сүлжээ

ЕРӨНХИЙ ТОЙМ

Энэхүү судалгаагаар Монгол улсын нийт хүн амын тал хувийг эзэлдэг эмэгтэйчүүд, 1/3-ийг эзэлдэг залуучуудын улс төр болон сонгуулийн үйл явцад идэвхтэй, ижил тэгш оролцоход тулгардаг хамгийн түгээмэл саад бэрхшээлүүд, тэдгээрийг багасгахад чиглэсэн дүгнэлт, зөвлөмжийг хүргэж байна.

Судалгаанд Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн, түүний салбар Эмэгтэйчүүдийн ардчиллын сүлжээ байгууллагуудын боловсруулсан “SheVotes” аргачлалыг ашиглав. Энэхүү аргачлал нь улс төрийн оролцоонд тулгарч буй саад бэрхшээлүүдийг

1. Засаглалын (хууль эрх зүй, институцийн)
2. Нийгэм – соёлын
3. Хувь хүний түвшинд судалдаг.

Монгол эмэгтэйчүүд, залуучуудад улс төр, сонгуулийн үйл явцад идэвхтэй, ижил тэгш оролцоход тулгардаг томоохон саад бэрхшээлүүд нь засаглалын шинж чанартай болох нь энэхүү судалгааны тайланд тусгагдсан.

“SheVotes” -ийн аргачлалаар цахим судалгаа, зорилтот бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагууд гэх мэт олон сувгаар цуглуулсан өгөгдөлд үндэслэн монгол эмэгтэйчүүд, залуучууд идэвхтэй, ижил тэгш улс төр, сонгуулийн үйл явцад оролцоход олон адармаатай саад бэрхшээлтэй тулгардаг гэдгийг нотлов. Санхүүгийн бэрхшээлээс авахуулаад улс төрийн намуудаас эмэгтэй, залуу гишүүддээ системтэй дэмжлэг үзүүлдэггүй зэрэг нь эмэгтэйчүүд, залуучуудад тулгардаг гол бэрхшээл болж байна. Түүнчлэн, хэдийгээр эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх тал дээр жендэрийн квот зэрэг шинэчлэлээр дамжуулан тодорхой ахиц дэвшил гаргаж байгаа ч иймэрхүү арга

хэрэгслүүд зөвхөн тодорхой хэмжээнд л үр дүн авчирчээ. Үүнийг улс төрийн намууд квотоо биелүүлэх төдий байх, улс даяар квотын хамгийн доод шаардлагыг хангахад хүндрэлтэй газрууд цөөнгүй байдгаас харж болно. Үр дүнд нь, хэдийгээр “Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль”-д “улс төрийн шийдвэр гаргах түвшинд нэр дэвшигчдийн аль нэг хүйсийн төлөөлөл 20%-иас багагүй байна” гэсэн шаардлага буюу босго зааж өгсөн ч, энэ нь бодит байдалд олон гишүүдтэй улс төрийн намын эмэгтэй улстөрчид/нэр дэвшигчдэд босго бус “тааз” болж, улс төрийн намуудын эмэгтэй нэр дэвшигчдийн тоо энэхүү доод шаардлагад хүрэхгүй байна. Асуудлыг лавшруулан харвал намууд жендэрийн квотыг хангаж, эмэгтэй гишүүдээ нэр дэвшигчдийн жагсаалтад оруулсан ч, тухайн нам ялах магадлал хамгийн бага, хамгийн өрсөлдөөнтэй тойргуудад хуваарилах нь түгээмэл байна. Энэхүү асуудлыг шийдвэрлэхийн тулд холбогдох хууль дүрэм журамд илүү тодорхой заалтуудыг нэмж тусгах шаардлагатай.

Нийгмийн саад бэрхшээлийн хувьд, хэдийгээр монгол эмэгтэйчүүд харьцангуй бие даасан, өндөр боловсролтой, иргэний нийгмийн идэвхтэй оролцогчид боловч эмэгтэйчүүд гэр орны ажлаа хийх, хүүхдээ асрах үүргүүдийг илүү хүлээх ёстой гэсэн нийгмийн хэвшмэл ойлголт болон хүлээлт нь эмэгтэйчүүдийг иргэний оролцоогоо нэмэгдүүлэх, улс төрийн карьер хөөхөд саад болдог. Иймэрхүү бэрхшээл хөдөө орон нутагт илүү тохиолдох ба улс төрийн идэвхтэй, эсвэл дөнгөж улс төрийн карьераа эхэлж буй эмэгтэйчүүдийг олон нийт хатуугаар шүүмжлэх, хэвлэл мэдээлэлд голцуу сөрөг талаас нь харуулах, эсвэл хувь

хүний ур чадвар, туршлагаас илүүтэй хувийн амьдрал, гадаад үзэмжээр нь дүгнэх нь түгээмэл байна. Эмэгтэйчүүдийг ахуйн чанартай жижиг хэмжээний асуудлуудыг л хариуцах чадамжтай, сайн гүйцэтгэгчид боловч шийдвэр гаргах чадамжгүй гэх түгээмэл явцуу ойлголтуудаас гадна залуучуудыг түүхий, туршлага дутмаг гэж өнгөцхөнөөр дүгнэх нь эмэгтэйчүүд, залуучуудын улс төрийн шийдвэр гаргалтад оролцоход шууд болон шууд бусаар нөлөөлдөг.

Хувь хүний саад бэрхшээлийн тухайд, улс төрийн карьер хөөх үйл явц нь маш их тэвчээр, санхүү, цаг хугацаа, ур чадвар, боловсролын нөөц, боломж бололцоо, тэвчээр, золиос гаргахыг шаарддаг тул дийлэнх нь хувь хүний цаг зав, амьдралын хэв маягтай холбоотой бэрхшээлүүд байна.

“SheVotes” аргачлалаар тодорхойлсон саад бэрхшээлүүдийг даван туулж, эмэгтэйчүүд, залуучуудын улс төрийн оролцоог сайжруулахад чиглэсэн зөвлөмжүүдийг энэхүү тайланд оруулав. Үүнд, Сонгуулийн ерөнхий хорооноос манлайлан зөвхөн сонгуулийн үеэр хязгаарлагдахгүйгээр сонгогчдын боловсролд чиглэсэн үндэсний хэмжээний хөтөлбөрийг насны бүлэг, хүйс, ажил мэргэжлийнх нь онцлогт тохирсон хэлбэрээр байнга зохион байгуулах, парламентын болон засгийн газрын гишүүд “Сонгуулийн тухай хууль”-ийн тодорхой заалтуудад (тухайлбал эмэгтэйчүүдийн жендэрийн квотыг 20%-иас нэмэгдүүлэх) нэмэлт өөрчлөлт оруулах, хэвлэл мэдээлэл болон иргэний нийгмээс уг хуульд шаардлагатай нэмэлт өөрчлөлтүүдийг оруулахаар ажиллах, эмэгтэйчүүд, залуучуудын улс төрийн оролцоонд сөргөөр нөлөөлдөг нийгэмд хэвшсэн сөрөг ойлголтуудыг өөрчлөхөд чиглэсэн контент бэлтгэж, хүргэх зэрэг зөвлөмжүүдийг багтаав.

Цахим судалгаа, зорилтот бүлгийн ярилцлага, ганцаарчилсан ярилцлага зэрэг олон сувгаар цуглуулсан өгөгдөлд үндэслэн, “SheVotes” судалгааны хүрээнд дараах үндсэн дүгнэлтүүдэд хүрлээ.

Үндсэн дүгнэлт

Дүгнэлт 1: Эмэгтэйчүүд сонгуульд оролцоход тогтоодог “жендэрийн квот”-ын хэрэгжилт хангалтгүй байна

Хэдийгээр улс төрийн намууд сонгуульд нэр дэвшигч эмэгтэйчүүдийн жагсаалтдаа жендэрийн квотыг мөрдөх болсон нь дэвшилттэй боловч бодит байдалд энэхүү зохицуулалт нь эмэгтэй нэр дэвшигчдийг дэвшүүлэх доод “босго” биш “тааз” гэж ойлгогддог.

Дүгнэлт 2: Сонгуулийн кампанит ажил хийх зардал өндөр байдаг нь эмэгтэйчүүд, залуучуудад улс төрд оролцоход томоохон санхүүгийн саад бэрхшээл болдог

Сонгуулийн кампанит ажлын зардал өндөр, нэр дэвшигчдийг өөрсдөө санхүүжилтээ гаргах ёстой гэдэг хүлээлт эмэгтэйчүүд, залуучуудын улс төрийн оролцоонд ихээхэн бэрхшээл үүсгэдэг.

Дүгнэлт 3: Байнгын оршин суух хаяг дээрээ сонгуульд оролцох шаардлага, иргэний бүртгэлтэй холбогдох үйл явц нь залуучууд сонгуульд оролцож чадахгүй байх нэг том шалтгаан болдог

Улаанбаатар хотод ажиллах юмуу сурах зорилгоор түр оршин сууж буй залуучууд байнгын оршин суух хаягаа төдийлэн өөрчилдөггүй учир түр оршин суух хаяг дээрээ сонгуульд оролцох боломжгүй байдаг. Түүнчлэн, гадаадад оршин сууж буй монгол залуучууд цахимаар болон шуудангаар саналаа өгөхийн оронд заавал Монгол улсын

ЭСЯ-ны байранд биечлэн очиж санал өгөхийг шаарддаг. Энэ мэт хатуу шаардлагууд залуучуудын сонгуулийн оролцоонд сөргөөр нөлөөлдөг.

Дүгнэлт 4: Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хүлээх үүргийн талаар тогтсон ойлголтууд болон нийгмийн хүлээлт эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог бууруулдаг

Улс төрд оролцдог эмэгтэйчүүдийг ихэвчлэн “амбицтай” гэж сөргөөр, шударга бусаар шүүмжилдэг. Түүгээр зогсохгүй, эмэгтэйчүүдийг элдвээр гүтгэж, сөрөг сэтгэгдэл бичдэг нь улс төрд орохыг зорьж буй эмэгтэйчүүдийг шийдвэрээсээ няцахад хүргэдэг. Цаашлаад, уламжлалт боловч одоо хүртэл нийгэмд оршдог жендэрийн хэм хэмжээний дагуу эмэгтэйчүүд улс төр, олон нийтийн ажил үйлсээс илүү гэр ахуйн үүргээ чухалчлахыг шаарддаг.

Дүгнэлт 5: Улс төр бол бохир гэдэг ойлголтоос болж эмэгтэйчүүд, залуучууд улс төрд оролцохгүй байхыг илүү үздэг

Улстөрчид голцуу авилгад идэгдсэн, фракцаар ажилладаг учир улс төр бол бохир гэсэн нийтлэг дүр зураг залуучуудын дунд түгээмэл байна.

Дүгнэлт 6: Улс төрийн намын дотоод бүтэц, зохион байгуулалт эмэгтэйчүүд, залуучуудыг элсүүлэх, манлайлах ур чадварыг нь хөгжүүлэхэд хангалттай дэмжлэг үзүүлж чадахгүй байна

Парламентад суудалтай намууд хэдийгээр эмэгтэйчүүд, залуучуудын квот мөрддөг боловч гишүүддээ зориулсан тодорхой карьер хөгжлийн хөтөлбөр юмуу менторинг тогтолцоо байдаггүй нь эмэгтэйчүүд, залуучуудыг нам, түүний доторх фракцууд болон ерөнхий системтэй танилцах гэж ихээхэн цаг хугацаа алдахад хүргэдэг. Гэтэл,

эмэгтэйчүүд, залуучууд өөрсдийн гэр бүл, үр хүүхдүүдээр зогсохгүй, эцэг эхээ харж хандах зэрэг олон үүрэг хүлээдэг тул нийгмийн болон/эсвэл улс төрийн идэвх, оролцоонд цаг зориулахдаа харам байдаг.



Дүгнэлт 7: Сонгогчдын боловсролд чиглэсэн системтэй дэмжлэг дутмаг байдаг нь эмэгтэйчүүд, залуучуудын улс төрийн оролцоо сул байхад нөлөөлдөг

Сонгогчдын боловсрол ихээхэн зөрүүтэй байгаа нь эмэгтэйчүүд, залуучуудын оролцоонд тулгарч буй бэрхшээлүүдийг даван туулахад саад учруулж байна. Одоогоор сонгогчдод чиглэсэн боловсролын кампанит ажлууд (хэрвээ хийгдвэл) ихэвчлэн сонгуулийн яг өмнө юмуу сонгуулийн үеэр хийгддэг нь олон нийтэд зориулсан тогтмол, цогц сонгогчдын боловсрол олгох хэрэгцээ шаардлагыг хангаж чадахгүй байгааг харуулж байна. Дээрх дүгнэлтүүдийг холбогдох дэмжлэг ишлэлийн хамт тайлангийн удаах хэсгүүдэд танилцуулна.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ



АРГАЧЛАЛ

Энэхүү судалгааны гол зорилго нь монгол эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо буюу ялангуяа залуучуудын иргэний болон улс төрийн оролцоонд тулгарч буй бэрхшээлүүдийг шинжлэх байв. Судалгааны хүрээнд дараах 3 асуултад хариулт олохыг зорив. Үүнд:

- 1) Эмэгтэйчүүд, залуучуудын улс төрийн оролцоонд саад болж буй гол бэрхшээл юу вэ?
- 2) Эдгээр саад бэрхшээлд институцийн, нийгэм-соёлын болон хувь хүний ямар хүчин зүйлс нөлөөлдөг вэ?
- 3) Эдгээр саад бэрхшээлийг арилгахын тулд авч болох арга хэмжээний талаар зөвлөмж өгөх.

АРГА ЗҮЙ

Энэхүү судалгааг хийхдээ БНОУХ-ийн боловсруулсанЭАС-ээс хэрэгжүүлдэг “SheVotes” аргачлалд үндэслэн бэлдсэн цахим асуулгаар 744 хүнээс судалгаа авснаас гадна улстөрч, улс төр судлаач, сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулагч ажилтан, ажиглагч, иргэний нийгмийн төлөөлөл гэх мэт улс төр, сонгуулийн бүх шатны үйл ажиллагаанд оролцдог төрөл бүрийн туршлагатай оролцогчдыг сонгон, хагас бүтэцчилэгдсэн ганцаарчилсан ярилцлагыг 15 удаа, фокус бүлгийн ярилцлагыг 8 удаа нийт 58 хүнтэй хийсэн. Мөн судалгааны хүрээнд холбогдох хууль тогтоомж, төсөл хөтөлбөрөөс боловсруулсан судалгааны тайлангуудтай танилцан, дүн шинжилгээ хийсэн. Тайлангийн төгсгөлд судалгааны асуулгуудыг хавсаргав.

Цахим асуулгыг авахдаа судалгаанд оролцогчдын мэдээлэлд үзүүлсэнчлэн орон нутаг, хот суурин газар, амьдарч буй орон сууцны төрөл, боловсролын ялгаатай байдлаас гадна зорилтот бүлгийн буюу ХБИ болон гадаад оронд амьдарч буй монгол иргэдийн төлөөллийг оролцуулахад онцгойлон анхаарав.

Мөн олон талт байдлыг хангах зорилгоор ГЯ болон ФБЯ-ын оролцогчдыг сонгохдоо нас,

хүйс, оршинсуугаа байрлал буюу хот эсвэл хөдөө амьдардаг эсэх, намын харьяалалтай эсэх, намын төлөөлөл тэнцвэртэй хангаж буй эсэх болон улс төрийн карьерын аль шатанд явж байгаа зэргийг харгалзан үзэж зохион байгуулав.

Энэхүү судалгаа нь чанарын судалгаа учир үр дүн нь нийт монгол эмэгтэйчүүд болон залуучуудын үзэл бодлыг төлөөлөх албагүй болно.

СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН МЭДЭЭЛЭЛ

Фокус бүлгийн ярилцлагын оролцогчид (43 оролцогч)

ФБЯ-ын дугаар	Хүйс	Бүлгийн нэр	Оролцогчдын тоо	Шалгуур
1	Эмэгтэй	Залуу эмэгтэй улстөрчид	5	40 болон түүнээс доош настай
2	Эмэгтэй	Эмэгтэй улстөрчид	5	Шийдвэр гаргах түвшний сонгуульт болон томилгооны албан тушаалд буй
3	Эмэгтэй ба Эрэгтэй	Залуу улстөрчид	5	40 болон түүнээс доош настай
4	Эмэгтэй ба Эрэгтэй	Орон нутгийн улстөрчид	7	40 болон түүнээс доош настай
5	Эмэгтэй ба Эрэгтэй	Улс төр судлаачид	5	Их дээд сургууль, судалгааны байгууллагын судлаачдын төлөөлөл
6	Эмэгтэй ба Эрэгтэй	Сонгуулийн ажиглагчид	4	Иргэний нийгэм төлөөлөл
7	Эмэгтэй ба Эрэгтэй	Сонгуулийн зохион байгуулагчид	6	Хороо, баг болон гадаадад сонгуулийн үйл ажиллагаа зохион байгуулсан ажилтнууд
8	Эмэгтэй ба Эрэгтэй	Гадаадад амьдарч буй иргэд	6	Гадаадад амьдарч буй

Ганцаарчилсан ярилцлагын оролцогчид (15 оролцогч)

Г Я - н Дугаар	Хүйс	Албан тушаал	Харьяалал
1	Эмэгтэй	Улс төр судлаач	Их дээд сургууль (судалгааны байгууллага)
2	Эмэгтэй	Улс төр судлаач	Их дээд сургууль (судалгааны байгууллага)
3	Эрэгтэй	Залуу улстөрч	Намын гишүүн (ХҮН)
4	Эмэгтэй	Залуу улстөрч	Намын гишүүн (МАН)
5	Эрэгтэй	Улс төрийн кампанит ажил зохион байгуулагч	Нам бус
6	Эрэгтэй	Улс төр судлаач	Нам бус, ИН
7	Эрэгтэй	Залуу улстөрч	Намын гишүүн (МАН)
8	Эрэгтэй	Залуу улстөрч	Намын гишүүн (АН)
9	Эрэгтэй	Залуу улстөрч	Намын гишүүн (АН)
10	Эмэгтэй	Залуу улстөрч	Нам бус, (ИН)
11	Эрэгтэй	Улс төр судлаач	Нам бус, (ИН)

12	Эмэгтэй	Улс төр судлаач	Их дээд сургууль (судалгааны байгууллага)
13	Эрэгтэй	Улс төр судлаач	Нам бус, (ИН)
14	Эрэгтэй	Нийгмийн идэвхтэн	Намын гишүүн (АН)
15	Эмэгтэй	Туршлагатай улстөрч	Намын гишүүн (ИЗНН)

Асуулга бөглөгчдийн хүн ам зүйн мэдээлэл (744 оролцогч)

Хүйс		Ажил эрхлэлтийн байдал	
Эмэгтэй	67%	Сурагч	0.5%
Эрэгтэй	33%	Оюутан	16.8%
Нас		Бүтэн цагийн ажилтан	51.9%
18-25	25%	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	13.7%
26-30	13%	Ажилгүй	5.0%
31-35	19%	Тэтгэвэрт гарсан	3.4%
36-40	18%	Малчин	0.7%
41-50	18%	Группд байдаг	7.8%
51-60	6%	Бусад	0.3%
61+	1%		
Боловсрол		Байршил	
Албан боловсрол эзэмшээгүй	0.7%	Улаанбаатар	66%
Бага	0.5%	Гэр хороолол	12%
Бүрэн бус дунд	1.6%	Орон сууцны хороолол	54%
Бүрэн дунд	15.7%	Орон нутаг	32%
Техник мэргэжлийн	2.7%	Аймаг	20%
Их дээд сургууль	78%	Сум	12%
Хариулахыг хүсэхгүй байна	0.8%	Гадаад улс	2%

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

АГУУЛГЫН ТОВЧ

Засаглалтай холбоотой саад бэрхшээлүүд

Энэхүү судалгаанд эмэгтэйчүүд, залуучуудын улс төрийн оролцоонд тулгарч буй олон саад бэрхшээлийг авч үзэв. Эмэгтэйчүүд, залуучуудад тулгарч буй томоохон бэрхшээлүүд нь хууль эрхзүй, институцийн хүчин зүйлс буюу голцуу сонгуулийн тогтолцоо, улс төрийн намуудын дадал, арга барил гэх мэт засаглалтай холбоотой саад бэрхшээлүүд байна. Энэхүү ангилалд хамаарах саад бэрхшээлүүд нь Монголын улс төрийн системд олон жилийн турш ужгарсан тогтолцооны шинжтэй бэрхшээлүүд байгаа бол бусад ангилалд багтах бэрхшээлүүд нь сүүлийн үед илүү тод ажиглагдаж байна.

Түүнчлэн, хэдийгээр эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх тал дээр жендэрийн квот зэрэг шинэчлэлээр дамжуулан тодорхой ахиц дэвшил гаргаж буй ч иймэрхүү арга хэрэгслүүд зөвхөн тодорхой хэмжээнд л үр дүн авчирчээ. Үүнийг улс төрийн намууд квотоо биелүүлэх төдий байх, улс даяар квотын хамгийн доод шаардлагыг хангахад хүндрэлтэй газрууд цөөнгүй байдгаас харж болно. Үр дүнд нь, хэдийгээр “Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль”-д улс төрийн шийдвэр гаргах түвшинд нэр дэвшигчдийн аль нэг хүйсийн төлөөлөл 20%-иас багагүй байна гэсэн шаардлага буюу босго зааж өгсөн ч, энэ нь бодит байдалд олон гишүүдтэй улс төрийн намын эмэгтэй улстөрчид/нэр дэвшигчдэд “босго” бус “тааз” болж, улс төрийн намуудын эмэгтэй нэр дэвшигчдийн тоо энэхүү доод шаардлагад хүрэхгүй байна. Асуудлыг лавшруулан харвал намууд жендэрийн квотыг хангаж, эмэгтэй гишүүдээ нэр дэвшигчдийн жагсаалтад оруулсан ч, тухайн нам ялах магадлал хамгийн бага, хамгийн өрсөлдөөнтэй тойргуудад хуваарилах нь түгээмэл байна. Энэхүү асуудлыг шийдвэрлэхийн тулд холбогдох хууль дүрэм журамд илүү тодорхой заалтуудыг нэмж тусгах шаардлагатай.

Нийгмийн саад бэрхшээлүүд

Нийгэм – соёлын хүчин зүйлс эмэгтэйчүүд, залуучуудын улс төрийн оролцоонд саад учруулдаг төдийгүй “She Votes” судалгааны хүрээнд илэрсэн зарим нэг нийгэмд бугшсан саад бэрхшээлүүдийн ул суурь болдог байна. Хэдийгээр монгол эмэгтэйчүүд харьцангуй бие даасан, өндөр боловсролтой, иргэний нийгмийн идэвхтэй оролцогчид боловч “эмэгтэйчүүд юуны түрүүнд гэр орны ажил хийх, хүүхдээ асрах үүрэг хүлээх ёстой” гэсэн урт удаан хугацаанд нийгэмд хэвшсэн ойлголт нь эмэгтэйчүүдийг иргэний оролцоогоо нэмэгдүүлэх, улс төрийн карьер хөөхөд саад учруулдаг байна. Энэхүү судалгааны оролцогчид улс төрд өрсөлдөж, шийдвэр гаргах түвшинд хүн амд эзлэх хувьтайгаа дүйцэх хэмжээний төлөөлөл үүсгэхэд нь дээр дурдсан хэвшмэл ойлголтууд сөргөөр нөлөөлдөг болохыг онцолж байв. Түүнчлэн, эрэгтэйчүүд удирдах, харин эмэгтэйчүүд гэр ахуйн буюу үр хүүхдээ асрах үүрэгтэй хэмээх уламжлалт ойлголтууд сөрөг нөлөөтэй байна. Эцэст нь, гэр бүлийн зүгээс дэмжлэг үзүүлэхгүй байх, улс төрийг бохир гэж үзэх нь эмэгтэйчүүд, залуучуудын улс төрийн оролцоонд мөн саад учруулдаг байна.

Хувь хүний түвшин дэх саад бэрхшээлүүд

Улс төрд идэвхтэй оролцоход эмэгтэйчүүд, залуучуудад саад учруулах хүчин зүйлс нь институц, нийгэм – соёлоос гадна хувь хүнээс ч мөн хамаарна. Ямар ч ажил мэргэжилд ахиц дэвшил гаргахын тулд тодорхой түвшний боловсрол, ур чадвар шаардлагатай байдагтай адил улс төрийн карьерт амжилт олоход хувь хүнээс тууштай зүтгэл, манлайлал, зохион байгуулалт, зориг, ур чадвар, цаг хугацаа, санхүүгийн болон бусад нөөцийг шаарддаг тухай судалгаанд оролцогчид онцолж байв. Ялангуяа, сонгуулийн кампанит ажилд өндөр

зардал гарах, нэр дэвшигчид өөрсдөө кампанит ажлын зардлаа хариуцах зэрэг санхүүгийн бэрхшээлүүд нь эмэгтэйчүүд, залуучуудын сонгогдох эрхээ эдлэхэд бүтцийн болон хувь хүний түвшинд олон бэрхшээлийг бий болгож байна.

Дүгнэвэл, залуучуудын санхүүгийн тогтвортой бус байдал, иргэний боловсрол буюу сонгуулийн ерөнхий “нөү - хау” дутмаг байдаг нь тэдний сонгуулийн саналыг худалдаж авах зэрэг сөрөг нөлөөтэй үйл ажиллагаанд автах эрсдэлийг нэмэгдүүлдэг. Мөн, эмэгтэйчүүдэд тулгардаг нийгэм – соёлын бэрхшээлтэй адил гэр бүлийн дэмжлэггүйгээр залуучууд ч улс төрийн оролцоогоо бэхжүүлэх боломжгүй байна. Иймд, улс төрд оролцож, олон нийтийн зүгээс ирэх сөрөг дарамтад авталгүй тууштай зүтгэхэд гэр бүлийн дэмжлэг амин чухал нөлөө үзүүлдэг байна.



ДҮГНЭЛТ, ШИНЖИЛГЭЭ

Дүгнэлт 1: Эмэгтэйчүүд сонгуульд оролцоход тогтоодог “жендэрийн квот” -ын хэрэгжилт хангалтгүй байна

Хэдийгээр жендэрийн квот гэдэг томъёоллыг анх 2005 онд “Сонгуулийн тухай хууль”-д тусгасан боловч дөнгөж 2011 оноос л хэрэгжиж эхлэхдээ эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд томоохон түлхэц болжээ. Хэдий тийм боловч хүснэгт 1-д харуулсанчлан сонгууль бүрийн өмнө л квотын босго өөрчлөгддөг байсан төдийгүй хэрэгжилтэд тодорхой хязгаарлалтууд хийдэг байснаас эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх тал дээр бүрэн дүүрэн дэмжлэг болж чадаагүй. Тухайлбал, 2019 онд “Сонгуулийн тухай хууль”-ийн 30.22 дугаар зүйлд квотыг 30% байсныг “улс төрийн нам болон эвслүүдээс нэр дэвшигчдийн 20%-иас доошгүй нь аль нэг хүйсийнх байна” гэж бууруулж оруулсан. Ингэж эмэгтэйчүүдийн квотыг бууруулсан нь улс төр дэх жендэрийн зөрүүтэй байдлыг багасгахад ухралт болсон. Мөн өмнө дурдсанчлан, улс төрийн намууд жендэрийн доод квотыг “босго” биш “тааз” мэт хандаж ирсэн.

Жендэрийн квот жинхэнэ утгаараа хэрэгжихгүй байгааг улс төрийн намуудын шийдвэр гаргах түвшинд ч харж болно. Тухайлбал, МАН, АН аль аль нь улс төрийн шийдвэр гаргалтад эмэгтэйчүүд, залуучуудаа оролцуулах квотыг зааж өгсөн байдаг. Жишээлбэл, МАН-ын нийт гишүүдийн дор хаяж 30% нь эмэгтэйчүүд байна гэж заасан. Харин АН-ын хувьд нийт гишүүдийн ¼ нь эмэгтэйчүүд, ¼ нь 39-өөс доош насны залуучууд байна гэж заажээ.

ФБЯ-ын ярилцлагад оролцсон УИХ гишүүн: “Квотыг дээд хязгаар биш доод хязгаар байгаасай гэж хүсдэг. Нэг эмэгтэйг оруулахад нөгөө эмэгтэйг нь хасдаг гэдэг шиг шинээр олон эмэгтэйчүүд орж ирсэн ч, өмнө нь байсан чадварлаг эмэгтэйчүүдийг гаргаад оруулж

байгаа юм. Гэтэл эрэгтэйчүүдэд ийм асуудал тохиолддоггүй нь квотыг “тааз” гэж хүлээж авч буйн илрэл юм. Улс төрийн намуудын эмэгтэйчүүдийн бүлгүүд болон олон улсын байгууллагууд энэ талаар дуугарах хэрэгтэй. Миний бодлоор хэрвээ бид жендэрийн квотыг 20%-иас 25%, цаашлаад 30% болгож нэмэгдүүлбэл, эмэгтэйчүүд улс төрд квоттой, квотгүй илүү идэвхтэй оролцдог болно.”

Мөн судалгаанд оролцогчид хэдийгээр эмэгтэйчүүд намаасаа квотоор нэр дэвшдэг ч ихэвчлэн хамгийн өрсөлдөөнтэй тойргуудад хуваарилагддаг болохыг хэлж байв.

Хүснэгт 1: УИХ-ын сонгуулийн тухай хуульд орсон жендэрийн квотын тухай өөрчлөлт

Өөрчлөлт орсон он	2005*	2011	2015	2016 /05/05**	2019
Эмэгтэйчүүдийн квот	30%	20%	30%	20%	20%

Эх сурвалж: СЕХ

*2007 онд цуцалсан.

**2016 оны сонгуулиас өмнө өөрчлөлт оруулсан

Тодруулбал, “Зарим тойргуудыг зөвхөн эмэгтэйчүүдийнх гээд хүчтэй эмэгтэйчүүдийг хооронд нь өрсөлдүүлээд нэгийг нь л гаргадаг. Бас квотоор арай чамай орж буй эмэгтэйчүүдийг үхлийн тойргууд руу өрсөлдүүлдэг. Тэгэхээр үр дүнд нь бага л эмэгтэйчүүд сонгогдож байна даа” гэж ФБЯ-д оролцсон эмэгтэй УИХ-ын гишүүн онцолж байв.

Дүгнэлт 2: Сонгуулийн кампанит ажил хийх зардал өндөр байдаг нь эмэгтэйчүүд, залуучуудад улс төрд оролцоход томоохон санхүүгийн саад бэрхшээл болдог

Сонгуулийн кампанит ажлын зардал өндөр, үүнийгээ нэр дэвшигчдийг өөрсдөө санхүүжүүлэх ёстой гэдэг хүлээлт эмэгтэйчүүд, залуучуудын улс төрийн оролцоонд ихээхэн

бэрхшээл үүсгэдэг. Судалгаанд оролцогчид шийдвэр гаргах түвшинд нэр дэвшигчид намдаа “дэнчингийн мөнгө” заавал төлөх ёстой байдаг, нэмээд олон нийтээс кампанит ажлын зардлаа хандиваар босгож чадахгүй бол өөрсдөө бүх зардлаа хариуцах хэрэгтэй болдог гэдгээ хуваалцсан.

ФБЯ-ын оролцогч, залуу улстөрч эмэгтэйн хэлснээр: “Би намын аппаратад их удсан (10 жил), олон хүний сонгуулийн ажилд оролцож байсан учраас тэдний дэмжлэг, хандив болон өөрийн сонгууль зохион байгуулах туршлагыг ашиглан маш хэмнэлттэйгээр өөрийн сонгуулийн кампанит ажлаа зохион байгуулж чадсан. Гэсэн хэдий ч надад байхгүй хэмжээний мөнгө зарцуулагдсан. Уг мөнгийг тухайн үедээ кредит картаа ашиглан гаргасан. Би орон нутгийн сонгуульд нэр дэвшсэн ч, УИХ-ын сонгуульд нэр дэвшээгүй нь миний хувьд үндэсний хэмжээнд өрсөлдөхүйц санхүүгийн чадваргүй байсантай холбоотой.”

Кампанит ажлын зардал өндөр болсон нь нэр дэвшигчийг боловсрол, туршлагаас илүүтэйгээр кампанит ажлын зардлаа өөрөө гаргах чадамжтай байхыг илүү чухалчилхад хүргэж байна. Өөр нэгэн залуу улстөрч: “Намайг нэр дэвших болоход орон нутгийн намын удирдлага намайг өөрөө зардлаа хариуцаж чадах уу гэж асуусан. Тэр үед боловсрол, туршлага бол санхүүгийн боломжийн дараа ордог юм байна гэдгийг ухаарсан” гэж ярьсан.

Судалгаанд оролцогчид ил болон далд санал худалдаж авах ажиллагаа ихээхэн явагддаг талаар судалгааны багтай мөн хуваалцаж байлаа. Ийм учраас нэр дэвшигчид санхүүгийн чадамж өндөртэй байх шаардлагатай болдог ба утга учиртайгаар улс төрд өрсөлдөх гэсэн зарим нэр дэвшигчид хангалттай хэмжээний мөнгөгүйгээсээ болоод ард хоцордог. Сонгуулийн кампанит ажил зохион байгуулж байсан туршлагатай нэгэн ФБЯ-ын оролцогч: “Сонгууль болохоос 3-4 сарын өмнөөс нам маань сонгуулийн стратеги боловсруулдаг. Намын зүгээс сонгуулийн тойрогт харьяалагдах бараг

хүн бүрийн жагсаалт гаргаж, авч үздэг. Жишээлбэл, тэд ам бүл олуулаа, хамаатан садан ихтэй хүнийг ухуулагчаараа авдаг” гэж хуваалцсан.

Хуулийн хүрээнд мөртлөө санал худалдан авч буй бас нэгэн процесс бол ухуулагчдыг 420,000₮-өөр цалинжуулж, гэр бүл, ойр дотныхоо хамгийн багадаа 10 хүнийг тодорхой нэр дэвшигчид санал өгүүлэхээр тохиролцдог. Улс төр өөрөө ихээхэн зардалтай бөгөөд олон үйл ажиллагаа явуулж, тактиктэй байхыг шаарддаг. Ухуулагчидтай хийдэг дээрх мэт тохиролцоо нь томоохон болон өндөр зардалтай үйл ажиллагааны нэгэн жижиг хэсэг юм. ГЯ-ын оролцогч, улс төрийн кампанит ажлын зохион байгуулагчийн хэлснээр, “2020 оны сонгуулийн үеэр одоогийн парламентын гишүүд дунджаар нэг хүний 363 сая ₮ зарцуулсан нь нэр дэвшээд ялагдсан өрсөлдөгчдөөсөө 3.6 дахин их хөрөнгө зарцуулсан гэсэн үг юм. ҮСХ-ны мэдээгээр нэг хүнд ногдох дундаж сарын цалин 1.32 сая ₮, тэгэхээр дундаж Монгол иргэн шийдвэр гаргах түвшинд өрсөлдөхийн тулд 23 жилийн турш цалингаа өөр юунд ч зарцуулахгүйгээр хадгалах шаардлагатай болно гэсэн үг. Энэ хэмжээний мөнгө нь хувийн бизнес л эрхэлдэггүй юм бол эмэгтэйчүүд болон залуучуудын хувьд голдуу хол санагдана.”

Дүгнэлт 3: Байнгын оршин суух хаяг дээрээ сонгуульд оролцох шаардлага болон иргэний бүртгэлтэй холбоотой процесс нь залуучуудад сонгуульд оролцож чадахгүй байх нэг том шалтгаан болдог

Хэдийгээр засгийн газраас цахим системүүдийг сүүлийн жилүүдэд эрчимтэй хэрэглээнд нэвтрүүлж байгаа ч сонгогчдын бүртгэлийн систем, ялангуяа тус системийн нээлтэй байдал дутмаг, зарим ойлгомжгүй байдалтай холбоотой гомдол санал гарсаар байгааг судалгаанд оролцогчид санууллаа. УИХ-ын сонгууль зохион байгуулах тухай хуулийн 25.1 дүгээр зүйлд сонгогчид 2 дугаар сарын 15-наас хойш буюу сонгууль болох өдрөөс хэдэн сарын

урдаас хаягийн бүртгэлээ шинэчилж болохгүй гэж заасан байдаг. Мөн энэ ижил хязгаарлалт орон нутгийн сонгууль болохоос 60 хоногийн урдаас үйлчилж эхэлдэг нь олон сонгогчид саналаа өгөх боломжгүй болоход хүргэдэг. ФБЯ-ын оролцогч, залуу улстөрч: “Ширээн дээрээ хоолтой хоноход санаа зовж яваа хүмүүс сонгууль болохоос өмнө хаягийн бүртгэлтэй холбоотой шаардлагуудыг хангасан байх ёстой гэх зэрэг нарийн мэдээллийг цаг тухайд нь анзаараад аваад, хэрэгжүүлээд байдаггүй”.

2021 онд 1400 оролцогчоос авсан сонгогчдын судалгаагаар сонгогчдын саналаа өгдөггүй гол шалтгаануудын нэг нь хаягийн бүртгэлтэй холбоотой зөрчил гэж гарч ирсэн (Судлаач С.Болдсайхан). Энэхүү судалгаанд дурдсанаар УИХ-ын сонгуульд саналаа өгөөгүй нийт сонгогчдын 32%, орон нутгийн сонгуульд саналаа өгөөгүй нийт сонгогчдын 18% нь иргэний үнэмлэх дээрх хаягаасаа өөр газар оршин сууж байсан тул саналаа өгч чадаагүй гэж хариулсан байна. Хаягийн бүртгэлтэй холбоотой энэхүү асуудал нь залуу сонгогчид, ялангуяа өөрийн байнгын оршин суух хаягаасаа өөр газар суралцаж байгаа их дээд сургуулийн оюутнуудад шууд нөлөөлдөг байна. Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагаас 2018 онд хийсэн “Монголын хот руу шилжин суурьшигчдын эмзэг байдлын судалгаа”-ны дүгнэлтэд амьдрах байраа сольж, байнгын оршин суух хаяг тодорхойгүй байх нь нийгмийн үйлчилгээг тасалдалгүй авах, сонгуульд оролцох эрхээ эдлэх, шаардлагатай мэдээллийг авах, цаашлаад хот руу шилжин суурьшигчид хууль ёсны оршин суух зөвшөөрлөө авах, бусад газраас ирсэн иргэд авах боломжгүй байдаг үйлчилгээнүүдээ хүртэх боломжоор хангагдахад хүндрэл учруулдаг хэмээн дүгнэжээ.

Дүгнэлт 4: Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хүлээх үүргийн талаар тогтсон ойлголтууд болон нийгмийн хүлээлт нь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог бууруулдаг

Монгол эмэгтэйчүүд Азийн бусад олон орны эмэгтэйчүүдтэй харьцуулахад харьцангуй биеэ даасан. Хэдий тийм ч, олон үеийн турш эмэгтэйчүүд гэр орны ажлаа хариуцаж, эрэгтэйчүүд гадаах ажлаа зохицуулж ирсэн. Цаашлаад айл гэр эрэгтэйгээрээ овоглодог. Энэхүү уламжлалт байдал нь эрэгтэйчүүд гэр бүлийнхээ өмнөөс шийдвэр гаргаж, нийгмийн харилцаанд илүү давуу тал олох нөхцөлийг бүрдүүлсэн. Судалгаанд оролцогчид нийгэм – соёлын болон уламжлалт хэм хэмжээ эмэгтэйчүүд, залуучуудын шийдвэр гаргалтад төлөөлөл хангалтгүй байгаатай холбоотой гэдгийг хэлж байв. Үр дүнд нь нийгэмд тогтсон эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хүлээх үүрэг, нэг талыг барьсан итгэл үнэмшлүүд эмэгтэйчүүд, залуучууд улс төрийн шийдвэр гаргалтад шударга, чөлөөтэй өрсөлдөх боломжийг хаадаг. Эмэгтэйчүүд гэр ахуйн ажлаа хариуцаж, хүүхдээ өсгөх ёстой гэдэг жендэрийн үүргийн талаар тогтсон ойлголт нь эмэгтэйчүүдийн улс төрийн идэвхтэй байдлыг сулруулдаг.

Судалгааны турш оролцогчид эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хүлээх үүргийн талаарх тогтсон ойлголтууд болон нийгмийн хүлээлт нь эмэгтэйчүүд, залуучуудын улс төрийн оролцоонд сөргөөр нөлөөлдөг тухай нэлээдгүй удаа дурдаж байв. Хэдийгээр эмэгтэй улстөрчдийн талаарх нийгмийн хандлагад зарим эерэг өөрчлөлтүүд гарч эхэлж байгаа хэдий ч эмэгтэй улстөрчдийг нэг талаас гэр орны аж ахуйн үүргүүдээ биелүүлдэг эмэгтэйлэг байх, нөгөө талаас хүүхэд, халамж, эрүүл мэнд зэрэг сэдвээс цаадах яриа, хэлэлцүүлэгт оролцох хэмжээний чадамжтай байх баланстай байхыг шаардах зэрэг хандлагууд ажиглагдав.

Улс төрд идэвхтэй оролцдог эмэгтэйчүүд хүүхэдтэй болбол ихэвчлэн карьерын завсарлага авдаг. Эргээд ажилдаа ороход эрэгтэй хамт ажиллагсад нь карьерын шат ахиад явчихсан байдаг бол эмэгтэйчүүд ахиад эхнээс нь явах шаардлага тулгардаг. Эмэгтэй улстөрч хүүхэд төрүүлэх бүртээ дээрх үе шатыг

дамжих хэрэгтэй болбол улс төрөөс халширч эхэлдэг. Тэр ч бүү хэл, эмэгтэйчүүд улс төрд ороход удирдагч, манлайлагчийн үүрэг хүлээнэ гэхээс илүүтэйгээр захиргааны, бичиг цаасны ажил хийлгэх хүлээлт байдаг. ФБЯ-ын оролцогч нэгэн залуу улстөрч: “Эмэгтэйчүүд ихэнхдээ илүү хариуцлагатай байдаг учир сонгууль зохион байгуулах зэрэг улс төрийн намын гүйцэтгэх түвшний ажлын бараг 70%-ийг хариуцан ажиллаж байдаг. Гэсэн хэдий ч шийдвэр гаргах түвшинд төлөөлөл нь бараг байдаггүй гэж хэлэхэд болно. Энэ нь эмэгтэйчүүд илүү захиргааны, бичиг цаасны ажил хариуцаад, харин эрэгтэйчүүд удирдах түвшний албан тушаал хашдаг гэсэн түгээмэл дүр зурагтай холбоотой байх” гэж хуваалцсан.

Мөн өөр нэг ФБЯ-д оролцсон залуу улстөрч эмэгтэй: “Би жишээ нь хуралд оролцож байсан чинь нарийн бичиг охин бид хоёр л эмэгтэй байсан байх. Тэгсэн нөгөө охин маань тайз руу гарах болоод та протокол хөтөлж байгаач гэж надаас гуйж байсан. Би “яагаад би гэж? Энд зөндөө хүн байна шүү дээ” гэж асууж байсан. Тэр охины хувьд эрэгтэй хүмүүс биш эмэгтэй хүн л тэмдэглэл хөтлөх гэх мэт гүйцэтгэлийн ажлыг хийдэг гэсэн хэвшмэл бодол байсан байх” гэж хэлж байв.

Хөдөө орон нутагт хэвшмэл уламжлалт хандлага илүүтэйгээр байсаар байгаа тул хэдий эмэгтэйчүүд, залуучуудыг бага дунд шатанд дэмжиж байгаа ч дээд шатны шийдвэр гаргах түвшинд итгэл хүлээлгэх явдал бага байна.

УИХ-ын 7 удаагийн сонгуулийн туршид нийт 63 эмэгтэй УИХ-ын гишүүнээр сонгогджээ. Тэдний сонгогдсон тойргуудыг судалж үзэхэд 61,9% (39) нь нийслэл Улаанбаатар хотоос сонгогдсон байсан бол Завхан аймгаас сүүлийн 6 удаагийн сонгуулиар дарааллан эмэгтэй төлөөлөл сонгогдсон нь бусад аймагтай харьцуулахад хамгийн өндөр байлаа. Хэдийгээр нийслэлийн тойргийн тоо хөдөө орон нутгаас хоёр дахин бага байдаг ч эмэгтэйчүүдэд илүү ээлтэй байгаа нь ийнхүү харагдаж байна. (Хүснэгт 2)

Хүснэгт 2: Эмэгтэй УИХ-ын гишүүдийн сонгогдсон байршлууд

Байршил	Сонгогдсон эмэгтэй гишүүдийн тоо
Улаанбаатар	39*
Завхан аймаг	6
Хэнтий аймаг	4
Сэлэнгэ аймаг	4
Өмнөговь аймаг	3
Баянхонгор аймаг	2
Дорнод, Говьсүмбэр	2
Төв аймаг	1
Дорнод аймаг	1
Сүхбаатар аймаг	1
Нийт	63

Эх сурвалж: СЕХ, *2012 оны жагсаалтаар гарсан эмэгтэйчүүдийг УБ-д нэмэв.

Мөн энэхүү хүснэгтээс Монгол улсын 21 аймгийн талаас илүү хувь буюу 12 аймгаас 7 удаагийн сонгуулийн туршид нэг ч эмэгтэй гишүүн сонгогдож байгаагүйг харж болно. Зарим аймгууд, жишээлбэл, Баян-Өлгий, Увс гэх мэт аймгуудад эмэгтэй хүн УИХ-д нэр дэвшиж ч байгаагүй ажээ. Хөдөө орон нутагт яагаад эмэгтэйчүүдийн улс төрийн шийдвэр гаргах түвшний оролцоо сул байгааг судалгаанд оролцогчид дараах байдлаар тодорхойлж байлаа.

“Сумын хэмжээнд бол квотын 20%-аа хангах маш хүнд байдаг. Би дэвшье гээд гүйгээд ирдэг эмэгтэйчүүд ховор байдаг болохоор гайгүй амьдрал ахуйгаа авч явдаг, ажил төрөлтэй эмэгтэйчүүд дээр хадаг барин очиж улс төрд нам төлөөлөн өрсөлдөхийг гуйдаг”. Залуу улс төрч, ФБЯ-ын оролцогч.

“Суманд бол нэр хүндтэй эмэгтэйчүүдийн нөхрүүд нь мөн адил нийгмийн идэвхтэй байдаг. Тиймээс эмэгтэйчүүд нь “за, хоёулаа

улс төрийн ажил хийгээд яах вэ дээ. Нэг нь гэр орны ажлаа зохицуулах хэрэгтэй” гээд хойш суугаад байдаг. Ер нь суманд бол залуу эмэгтэйчүүд биш 40-өөс дээш насны эмэгтэйчүүд л улс төрд оролцож байгаа”. Залуу улс төрч, ФБЯ-ын оролцогч.

Дүгнэлт 5: Улс төр бол бохир гэх ойлголтоос болж эмэгтэйчүүд, залуучууд улс төрд оролцохгүй байхыг илүүд үздэг

Улс төр бол бохир гэх өргөн тархсан ойлголт нь эмэгтэйчүүд, залуучуудын улс төрийн оролцоог хазаарлаж байдаг. ФБЯ-ын оролцогч залуу улстөрч “Эмэгтэйчүүд, залуучууд улс төрийн талаарх олон нийтийн сөрөг хандлагаас болоод улс төрд оролцохоос цэрвээд байгаа санагддаг” гэж байв.

Мөн ФБЯ-ын оролцогч, залуу улс төрч: “Орон нутгийн түвшинд намын хуваалцал их. Эрх барьж буй намууд цөөн хэдэн ажлын байруудад очиж бүх шийдвэрийг гаргадаг. Тэгэхдээ шударга бусаар гаргадаг тул улс төрх бохир гэж энгийн иргэд хардаг. Сонгуулийн үеэр “тодорхой намын нэр дэвшигчдэд” саналаа өгөөгүй тохиолдолд хүнсний талоныг өгөхийг зогсооно шүү, ажиглаж байгаа шүү, ойр тойрныхныг нь болон өөрийг нь ажлаас хална шүү гэсэн заналхийлэл гарч байсан тохиолдлыг ч харж байсан. Ер нь улсаас халамж авах ёстой хүн ч байсан нөгөө намыг дэмжсэн бол халамж нь зогсоно. Ямар ч халамж авах шаардлагагүй, гэр бүлээрээ ажил хөдөлмөр эрхэлдэг, унах машин тэрэгтэй хүмүүс намыг дэмждэг учраас гээд халамжид орсон явж байхыгч харж байсан” гэж хуваалцаж байв.

Энэхүү судалгааны хүрээнд хийгдсэн онлайн асуулгыг бөглөсөн 744 оролцогчдоос “Та улс төрийг бохир, эмэгтэйчүүд болон залуучуудад тааламжгүй гэж боддог уу?” гэсэн асуултад 57,5% (428) нь тийм гэж хариулсан ба хүйсээр харьцуулан үзэхэд эмэгтэйчүүдэрчүүдээс 10% - р илүү бохир гэж үздэг гэж хариулжээ.(Зураг 5)

Зураг 5: Та улс төрийг бохир эмэгтэйчүүд болон залуучуудад тааламжгүй гэж боддог уу?



Улс төр бол бохир гэх ойлголт мөн шууд хамтарч ажиллах баг, хэлхээ холбоо байхгүйгээсээ болоод олон хүмүүс улс төрд орохоос татгалздаг. Судалгаанд оролцсон хүмүүсийн дийлэнх хувь нь адилхан боломж, хамтран ажиллах мэргэжлийн сүлжээ/хэлхээ холбоо хангалттай байхгүйгээс эмэгтэйчүүд, залуучууд улс төрийн оролцоогоо хумьдаг гэж ярьж байв. Үүнийг том утгаар нь харвал өнөөгийн улс төрийн тогтолцоо нь хувь хүний туршлага, гүйцэтгэлийн түвшингээс илүүтэй танил тал, хэн нэгний хэлхээ холбоо хэр хүчтэй байгаагаас хамааралтай байна. Иймд, хэдийгээр чадвартай эмэгтэйчүүд, залуучууд өөрийн ур чадвар, туршлага дээрээ үндэслээд улс төрд оролцох боломжийнхоо төлөө өрсөлдөж болох ч ихэнхдээ өөрсдийг нь шийдвэр гаргах түвшинд аваачих хэлхээ холбоо хэрэг болдог. ФБЯ-ын нэг оролцогч Монголын улс төрийн фракцын систем хэрхэн ажилд авах, ажлын хэлхээ холбоогоо үүсгэхэд нөлөөлдгийг доорх байдлаар тайлбарласан юм.

“Манай суманд, жишээ нь, эсрэг нам ялаад би ажлаа хүлээлгэж өгсөн. Тэгээд миний албан тушаал дээр нээлттэй зар тавьж дахин сонгон шалгаруулалт зарласан чинь чадвартай залуучууд очихгүй байсан. Учир нь хэдий би ажлаа сайн хийж байсан ч ажлаа хүлээлгэн өгөх хэрэгтэй болсон явдал нь залуучууд төрийн албан тушаалд ажлаа сайн хийж байсан ч нам л ялагдвал ажилгүй болчих тогтворгүй юм байна гээд шийргэнэж байсан. Тиймээс улс хөгжье гэвэл энэ сонгууль болгоноор албан тушаалтнуудыг сольж намын л гэх тодотголтой чадваргүй нөхдийг албан тушаалд дэвшүүлэхээ болих хэрэгтэй. Бид чинь нэг л Монгол улсыг хөгжүүлж, эндээ сайхан амьдармаар байгаа хүмүүс биз дээ уг нь”.

Дүгнэлт 6: Улс төрийн намын дотоод бүтэц, зохион байгуулалт нь эмэгтэйчүүд, залуучуудыг элсүүлэх, манлайллын тал дээр хөгжүүлэхэд хангалттай дэмжлэг үзүүлж чадахгүй байна

Парламентад суудалтай намууд дотроо эмэгтэйчүүд, залуучуудын квоттой байдаг боловч тэдэнд зориулсан тодорхой карьер хөгжлийн болон менторшип хөтөлбөр байдаггүй. Намууд хэдийгээр гишүүдийг элсүүлэх, тэдний удирдах ур чадварыг бүхий л талаар хөгжүүлэх талбар болох боломжтой боловч судалгаанд оролцогчдын онцолсноор өнөөгийн нөхцөл байдалд намууд хэнийг намд элсүүлэх, хэнийг хаана томилох вэ гэх зэрэг асуудлууд дээр зохицуулагчийн үүрэг гүйцэтгэж буй мэт ажиллаж байна.

Үүнийг илүү нарийвчлан авч үзвэл улс төрийн намуудын дотоод бүтэц, үйл ажиллагаа нь нээлттэй, шударга өрсөлдөх, ахиж дэвших процедурыг тодорхой болгосон бодлого, хэм хэмжээний хувьд учир дутагдалтай байгаа нь эмэгтэйчүүд, залуучуудын илүү идэвхтэй оролцоог хааж байна.

Тогтсон бүтэц бүхий байгууллагуудын хувьд улс төрийн намууд төв аппараттай, тэндээсээ улс даяарх бусад салбар байгууллагууд руугаа зааварчилгаа өгч ажиллаж байна. Монголын хамгийн том хоёр нам болох МАН, АН хоёр залуучууд, эмэгтэйчүүдийн тусдаа ТББ статустай байгууллагуудтай ба эдгээр нь онолын хувьд тус намуудад шинээр гишүүн элсүүлэх, элссэн гишүүдээ дэмжих үүрэгтэй.

Улс төрийн намуудын эмэгтэй, залуу гишүүд нам дотроо дэвших, удирдах ур чадвараа хөгжүүлэх хөтөлбөрүүдэд хамрагдах нь зөвхөн гишүүд гэлтгүй намууддаа ч ашиг тустай мэт санагдах боловч бодит байдал дээр энэ нь өөр байгаа юм. ФБЯ-д оролцогч, залуу эмэгтэй улс төрч, “Анх намд элсэхдээ би эмэгтэйчүүдэд зориулсан хүний нөөцийн томоохон бодлого болон менторшип хөтөлбөр байгаа гэж бодож байсан. Гэвч бодит байдал дээр, тийм зүйлс байгаагүй ба системийг бүрэн ойлгох хүртлээ нэлээдгүй хугацааг зарцуулсан” гэж хуваалцсан бол өөр нэг оролцогч ч “Ерөнхийдөө Оюутны Холбоо нь спорт, урлагийн уралдаан, Залуучуудын Холбоо - Шинэ жил, Эмэгтэйчүүдийн холбоо - Мартын 8, Ахмадын холбоо - Ахмадын баярын арга хэмжээ

л зохион байгуулдаг юм шиг идэвхгүй үйл ажиллагаатай байна. Намаас яг холбоодод санхүүжилт олгодоггүй болохоор энэнээс ч илүү гардаггүй байх л даа” гэж санал нийлж байв.

Түүнчлэн, өмнө дурдсанчлан улс төрд идэвхтэй оролцож, шийдвэр гаргах түвшинд хүрнэ гэдэг нь өөрөө их “үнэтэй”. Цөөн тооны эмэгтэйчүүд, залуучууд л энэ зардлыг даах чадвартай байдаг. Хэрэвзээ санхүүгийн болон цаг хугацааны ихээхэн золиос дээр нэмээд намын зүгээс тодорхой дэмжлэг байхгүй бол эмэгтэйчүүд, залуучууд улс төрийн карьер хөөх тал дээр гэр бүлээсээ дэмжлэг авна гэдэг томоохон сорилттой тулгардаг. БНОУХ-ээс 2020 онд хийсэн судалгаа болон НҮБХХ-өөс 2014 онд хийсэн хэлэлцүүлгийн үеэр оролцогчдын дурдсанчланаар, тодорхой хэлбэл, БНОУХ-ээс 2020 онд хийсэн судалгаанд оролцогчдын 69% нь өөрсдийнх нь харьяалагддаг намуудын зүгээс хангалттай дэмжлэг үзүүлдэггүй шалтгаанаар 40-өөс доош насны залуучууд улс төрийн идэвх оролцоо сулардаг гэсэн байна.

Дүгнэлт 7: Сонгогчдын боловсролд чиглэсэн системтэй дэмжлэг дутмаг байгаа нь эмэгтэйчүүд, залуучуудын улс төрийн оролцоо сулардаг нөлөөлдөг

Энэхүү судалгааны ярилцлага, бүлгийн хэлэлцүүлгүүдэд хамрагдсан дийлэнх оролцогчид төр засгаас сонгууль, иргэний оролцооны талаар мэдлэг, мэдээлэл олгох сонгогчдын боловсролд хангалттай анхаарал хандуулахгүй байгаа нь олон нийтийн, ялангуяа эмэгтэйчүүд, залуучуудын улс төрийн үйл явцад төдийлөн идэвхтэй оролцох сэдэл төрөхгүй байхад хүргэж байгааг онцолж байв. Монголд сонгогчдын бүртгэл автоматаар эсвэл заавал хийгдэх ёстой гэдгээс бусдаар сонгогчийн болон иргэний боловсролын системчилсэн аргачлал тогтоогүй байна. Судалгаанд хамрагдсан сонгууль зохион

байгуулагч: “Хүүхдүүд 18 нас хүрээд санал өгөх эрхтэй болох үедээ санал өгөх нь яагаад чухал болохыг ойлгодоггүй ба сонгуулийн үйл явцад оролцох тухай хангалттай мэдээлэлгүй байдаг” гэжээ.

Тиймээс эмэгтэйчүүд, залуучуудын улс төрийн оролцоог сайжруулах гол шийдлүүдийн нэг нь төрөөс зохих ёсоор санхүүжүүлэн дэмжлэг үзүүлж сонгогч болон иргэний боловсролын кампанит ажлыг системтэй, тогтвортой явуулах явдал юм. “Иргэд мэдээллийн хүртээмжгүй байдлаас болж улс төрд бага оролцдог санагдсан. Иймээс тэдэнд шаардлагатай мэдээлэл болон боловсрол олговол оролцоо нь нэмэгдэх болно” гэж ФБЯ-ын нэгэн оролцогч онцолж байв.

¹УИХ-ын гишүүн Ц.Мөнхцэцэг [нэгэн ярилцлагадаа](#) “Монголын төрийн өнгөрсөн 30 жилийн хугацаанд гаргасан хамгийн том алдаа нь сонгогчийн боловсролд анхаараагүй явдал. Сонгогчийн боловсролын чиглэлээр хэдэн судлаачид, эрдэмтэд л бага сага ажил хийж ирсэн. Төрөөс энэ чиглэлээр юу ч хийгээгүй. Төр шинээр сонголтдоо хийх гэж байгаа залуу сонгогчид руу чиглэсэн боловсролыг нь дээшлүүлэх чиглэлээр ажиллах хэрэгтэй байна” гэжээ.

Мөн ФБЯ-ын оролцогч залуу улс төрч: “Хэдийгээр цахим орчин хөгжиж байгаа ч, хөдөө орон нутагт мэдээлэл авах боломж хомс байдаг. Жишээ нь ямар нэг байгууллагаас тодорхой шийдвэр гаргасан гэж бодъё. Түүнийгээ хөдөө орон нутгийн иргэдэд түгээх ажиллагаа дутмаг байдаг тул би өөрөө мэдээллээ эрж олж авахаас өөр аргагүй болдог. Энэ мэт асуудлаас үүдэн би нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд өрсөлдөж, улмаар төлөөлөгч болсон” гэж хуваалцаж байв.

¹ УИХ гишүүн Ц.Мөнхцэцэгийн ярианаас, 2019.11.25, <http://www.zaluucom.mn/read/3h5be989>

Сонгогчдын боловсролын хөтөлбөр нь залуучуудыг, иргэдийг сонгуульд идэвхитэй оролцохыг сурталчилахаас илүү өргөн хүрээтэй байх нь зүйтэй. Тухайлбал, агуулгын хувьд жендэрийн мэдрэмжтэйгээр санал өгөх, жендэрийн тэгш байдал, нийгмийн хүртээмжтэй байдлын төлөө санал өгөх зэрэг нь илүү ач холбогдолтой.



ЗӨВЛӨМЖ

Эмэгтэйчүүд, залуучуудын улс төрийн оролцоонд тулгарч буй саад бэрхшээлүүдийг даван туулахад She Votes аргачлалын хүрээнд СЕХ, улс төрийн намууд, МУЗГ, ИНБ, хэвлэл мэдээллийн байгууллагууд болон сонгогчдод чиглэсэн дараах зөвлөмжийг хүргэж байна.

Оролцогч талууд	Авах арга хэмжээ (зөвлөмж)
Сонгуулийн Ерөнхий Хороо	<ul style="list-style-type: none"> • Сонгогчдын боловсролыг дээшлүүлэх чиглэлээр хүүхэд, залуучууд, ахмад настнууд зэрэг насны бүлэг тус бүрд чиглэсэн цогц хөтөлбөрийг зөвхөн сонгуулийн жилтэй үед бус харин тогтмол хэрэгжүүлж, үр дүнг хянаж, дахин сайжруулах замаар үндэсний хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх. • Гадаадад байгаа, тогтмол оршин суух бүртгэлтэй хаяг дээрээ сонгуульд оролцох боломжгүй иргэд, ялангуяа залуучуудыг цахимаар эсвэл шуудангаар гэх зэрэг арга замаар саналаа илгээж сонгуульд оролцох нөхцөлийг бүрдүүлэх. • ХБ иргэд болон бага насны хүүхэдтэй эмэгтэйчүүд, ахмад настай иргэд зэрэг тусгай болон онцлог хэрэгцээтэй иргэдийг сонгох эрхээ эдлэхийг дэмжсэн нэмэлт тохижилт, үйлчилгээг нэвтрүүлэх.
Улс төрийн намууд (ялангуяа парламентад суудалтай намууд)	<ul style="list-style-type: none"> • Нам дотроо эмэгтэйчүүд, залуучуудын оролцоог дэмжсэн хүний нөөцийн бодлогыг боловсруулж, менторшип зэрэг шинэлэг, үр дүнтэй хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, хэрэгжилтийг дүгнэж, тогтмол сайжруулдаг байх. • Шийдвэр гаргах процесст эмэгтэйчүүдийн тэгш оролцоог хангах үүднээс ажлын бус цагаар, зөвхөн эрэгтэйчүүдээрээ нийлж (тухайлбал, “эрчүүдийн клуб”) ажил ярилцаж, шийдвэр гаргадаг байдлыг зогсоохыг дэмжсэн байгууллагын соёл нэвтрүүлэхийг зорих. • Улаанбаатар хот болон орон нутгийн гишүүдийнхээ хөгжил, ёс суртахуун, залгамж халааг бэлтгэхэд эн тэнцүү анхаарах; Жишээлбэл, орон нутаг дах гишүүдээ УБ хот дах гишүүдтэйгээ холбож, групп менторинг уулзалтууд зохион байгуулах. • Намын дотоод дүрэм, журамдаа жендэрийн минимум квотоос дээш гарсан жендэрийн квоттой холбоотой зэрэг заалтууд нэмж тусгах. • Намын залуучууд, эмэгтэйчүүдийн байгууллагууддаа хангалттай санхүүгийн нөөц хуваарилж, намдаа шинээр гишүүд элсүүлэх, шийдвэр гаргах түвшинд бэлтгэх зэрэг тоймтой ажлууд хийх боломж олгох. • Намаас нэр дэвшигчид намдаа “дэнчингийн мөнгө” өгөх шаардлагыг арилгах. • Намдаа шинээр эмэгтэйчүүд, залуучуудыг элсүүлж, намд элсэх болон үйл ажиллагаанд нь оролцох процессыг илүү тодорхой болгох.

<p>УИХ, ЗГ-ын гишүүд</p>	<ul style="list-style-type: none"> • Эмэгтэйчүүдийн квот, гадаадад байгаа Монголчууд цахимаар саналаа өгөх боломжоор хангах, нэр дэвшигчид намдаа “дэнчингийн мөнгө” өгөхийг хориглох зэрэг хуульчилсан боловч бодит байдал дээр хэрэгжихээрээ хуульд зааснаас өөрөөр хэрэглэгдэж буй хуулийн зүйл, заалтуудад нэмэлт өөрчлөлт оруулах, тодотгох эсвэл хариуцлага тооцох чиглэлээр нэмэлт зүйл заалт оруулах. • Голлох шийдвэр гаргах албан тушаалуудад жендэрийн тэгш байдлыг хангах тухай УИХ, ЗГ-ын холбогдох дүрэм журмуудад өөрчлөлт оруулах. Тухайлбал, ЗГ-ийн гишүүн, Байнгын хороо болон дэд хороодын дарга нарын томилгоо. • Эмэгтэйчүүд, залуучуудад чиглэсэн уралдаан, тэмцээнээс илүүтэй тэдэнд тулгардаг асуудлыг шийдвэрлэх, тойрогтоо ажиллахад нь хэрэгцээтэй дэмжлэгийг үзүүлэх зэрэг урт хугацааны, тогтвортой хөтөлбөрүүдийг санаачлан, хэрэгжүүлэх. • УИХ дахь эмэгтэйчүүдийн бүлгийг дэмжиж, намын харьяаллаас үл хамааран эмэгтэй гишүүддээ үйлчлэх, хууль эрхзүйн болон бодлогын тэргүүлэх чиглэлүүдийг хэрэгжүүлэх үр дүнтэй талбар болгох.
<p>Иргэний нийгмийн байгууллагууд, ОУБ, Хэвлэл мэдээллийн байгууллагууд</p>	<ul style="list-style-type: none"> • Зөвхөн олон нийтийн гэлтгүй шийдвэр гаргагчдын жендэрийн мэдрэмжийг дээшлүүлэх үйл ажиллагааг хэвлэл мэдээлэл болон сошиал нөлөөлөгчидтэй хамтран хэрэгжүүлэх • Эмэгтэйчүүд, залуучууд улс төр, сонгуулийн тогтолцоонд илүү идэвхтэй, эрх тэгш оролцооноор нийгэмд авчрах эерэг үр дүн, нөлөөллийг судалж, баримттайгаар гаргаж олон нийтийг мэдээллээр хангах. Тухайлбал, сонгогчдын боловсролд чиглэсэн тогтмол контент бэлтгэж, улс төрийн сенсац, томоохон шийдвэрүүдийг мэдээлэхээс гадна тусдаа “Улс төр” буланд зориулж нийтлүүлэх • Мэдээллийн тэнцвэргүй байдлын төлөө идэвхитэй тэмцэх (тухайлбал, мэргэжлийн ёс зүйг аль болох өндөрт өргөж, мэдээллийн чанарыг сайжруулах), бүх албан хаагчдынхаа жендэрийн мэдрэмжийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, ялангуяа сэтгүүлчид, операторууд, продюссеруудаа эмэгтэй улстөрчдийн талаар нийтлэхдээ нийгмийн хэвшмэл ойлголтод бус мэргэжлийн, жендэрийн мэдрэмжтэй, агуулгад ач холбогдол өгөх
<p>Олон нийт</p>	<ul style="list-style-type: none"> • Эмэгтэйчүүд, залуучууд, улс төр, сонгуулийн талаарх хэвшмэл ойлголтуудаа эвдэж, хүн тус бүр, сэдэв тус бүрийг ялгаж салгаж, илүү үндэслэлтэйгээр, мэдээллийн үнэн бодит байдалд дүн шинжилгээ хийж, аливаа шийдвэрийг гаргаж, үг үйлдэл хийдэг байх

Эмэгтэй болон залуу улстөрчид	<ul style="list-style-type: none">• Нийгэм, олон нийтийн дунд тогтсон хэвшмэл ойлголтуудын нөлөөнд автахгүй адил эрхтэй, адил чадамжтай хүн гэдгээ урьтал болгож, улс төрд тууштай явж, зорьсон үр дүндээ хүрэх “сэтгэлзүйн дархлаа”-г өөрсдөдөө бий болгох• Өөрийг тань дэмждэг, хурцалдаг, зоригжуулдаг мэргэжлийн болон хувийн хүрээллээ зөв бүрдүүлж, улс төр, сонгуулийн тогтолцоонд хамтран ажиллах багаа бүрдүүлж, эерэг өөрчлөлт, зөв нөлөөллийн төлөө хамтдаа зүтгэх
Залуу сонгогчид	<ul style="list-style-type: none">• Аливаа сонгуулийн үр дүн таны ирээдүйг тодорхойлно гэдгийг ухамсарлаж, хэн нэгний ятгалаг, мөнгөн болон мөнгөн бус хэлбэрийн хахууль, бэлэг сэлтэд хуурталгүй, сонгуулиа идэвхтэй, бодлоготой өгөх сэтгэхүйд чармайн суралцаж, хэвшүүлэх

ХАВСРАЛТУУД

Хавсралт 1. Олон нийтийн судалгаагаар авсан асуумж

Асуултын зорилго	Асуултууд
Хүн ам зүйн ерөнхий мэдээлэл	1. Таны хүйс: a. Эмэгтэй b. Эрэгтэй c. Бусад
	2. Таны нас: a. 18-25 b. 26-30 c. 31-35 d. 36-40 e. 41-50 f. 51-60 g. 61+
	3. Таны боловсролын түвшин: a. Албан боловсрол эзэмшээгүй b. Бага c. Бүрэн бус дунд d. Бүрэн дунд e. Техник мэргэжлийн f. Дээд / коллеж g. Хариулахыг хүсэхгүй байна
	4. Таны юу хийдэг бэ? a. Сурагч b. Оюутан c. Бүтэн цагийн ажилтан d. Хувиараа хөдөлмөр эрхлэгч e. Ажилгүй f. Тэтгэвэрт гарсан g. Малчин h. Группэд байдаг i. Бусад
	5. Таны амьдарч буй байршил: a. Улаанбаатар хот b. Аймгийн төв c. Сум, баг d. Гадаад

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

	<p>6. Таны амьдарч буй сууцны төрөл:</p> <ul style="list-style-type: none"> a. Монгол гэр (гэр хороолол) b. Монгол гэр (хөдөө) c. Хувийн байшин (гэр хороолол) d. Хувийн байшин (бусад) e. Орон сууц f. Оюутны дотуур байр g. Бусад
<p>Нийтлэг хандлагыг тодорхойлох</p>	<p>7. Та улс төрийг бохир залуучууд болон эмэгтэйчүүдэд тааламжгүй гэж боддог уу?</p> <ul style="list-style-type: none"> a. Тийм b. Үгүй c. Мэдэхгүй / хариулахыг хүсэхгүй байна
	<p>8. Та улс төрийн сонгууль өгөхөд өөрийн нас, хүйс болон тусгай хэрэгцээнээсүүдэн ямар нэг хүндрэлтэй учирч байсан уу? (Тийм бол тайлбарлана уу)</p> <ul style="list-style-type: none"> a. Үгүй b. Тийм
	<p>9. Хэрэв сонгуульд өрсөлдөж буй хоёр нэр дэвшигч боловсрол, чадварын хувьд ойролцоо бөгөөд нэг нь 18-40 хүртэл насны, нөгөө нь 40-өөс дээш насны хүн байвал аль нэр дэвшигчийг дэмжих магадлалтай вэ?</p> <ul style="list-style-type: none"> a. 40-өөс дээш насны хүнийг b. 18-40 нас хүртэл хүнийг c. Нас ямар ч хамаагүй d. Мэдэхгүй
	<p>10. Та “40-өөс дээш насныхан залуу үеийнхнээс илүү сайн улс төрийн удирдагч болдог” гэдэгтэй санал нийлэх үү?</p> <ul style="list-style-type: none"> a. Тийм b. Үгүй c. Мэдэхгүй
<p>Сонгуулийн мэдээлэл цуглуулах үе шат</p>	<p>11. Таны бодлоор доорх сонгуулийн сурталчилгааны компанит ажлуудын аль нь илүү залуучуудын анхаарлыг татаж үр дүнтэй хийгдэж чаддаг бэ?</p> <ul style="list-style-type: none"> a. Сонгогчийн боловсролд хандсан танин мэдэхүйн b. Нам болон нэр дэвшигчийн сурталчилгаа c. Аль аль нь d. Мэдэхгүй

	<p>12. Та хамгийн сүүлийн сонгуульд оролцохдоо нэр дэвшигч болон сонгуулийн талаар хангалттай мэдээллийг авсан байсан уу?</p> <p>a. Тийм b. Үгүй c. Мэдэхгүй</p> <p>13. Хэрвээ хангалттай мэдээлэл авч чадаагүй бол ямар төрлийн мэдээллүүддутаг байсан бэ? (та хариултаа тайлбарлан бичнэ үү)</p> <p>14. Хэрвээ иргэд мэдээллээр дутаг, боловсрол муутай байвал энэ нь эрх баригчдад ашигтай байдаг гэдэгтэй та санал нийлэх үү.</p> <p>a. Тийм b. Үгүй c. Мэдэхгүй</p>
<p>Сонгуулийн оролцоог нэмэгдүүлэх</p>	<p>15. Залуучуудын сонгуулийн идэвх, оролцоог сайжруулахад яг ямар 1-2 тодорхой бэрхшээлийг шийдвэрлэх хэрэгтэй гэж та бодож байна? (хариултаа тайлбарлан бичнэ үү)</p> <p>16. Өнгөрсөн сонгуульд таны гэр бүл эсвэл ойрын хүрээллийн хүмүүсээс сонголтоо хийхэд тань ямар нэг байдлаар нөлөөлөхийг оролдож байсан уу?</p> <p>a. Тийм, тэд хэнийг сонгохыг шаргуу тулгасан b. Тийм, зарим нэг байдлаар тэгсэн c. Үгүй, би сонголтоо өөрийн шийдвэрээр хийсэн d. Асуултад хариулахыг хүсэхгүй байна</p>
<p>Сонгуулийн шийдвэр гаргалт</p>	<p>17. Хамгийн сүүлд өгсөн сонгуульд нэр дэвшигчийг дугуйлахдаа та шийдвэрээ хэрхэн гаргасан бэ?</p> <p>a. Сонгуулийн байран дээр очоод нэр дэвшигчдээс тухайн үеийнүзэмжээр сонголт хийсэн b. Нэр дэвшигчдийн мэдээлэлд бага хэмжээний судалгаа хийж хамгийнсайн гэсэн дэвшигчдээ тодорхойлж сонголтоо хийсэн c. Нэр дэвшигчдийн мэдээлэлд нухацтай судалгаа хийж олсон үр дүнгүүдээ өөрийн хүндэлдэг хүмүүстэй хэлэлцэж сонголтообаталгаатай хийсэн d. Би сонгууль өгөөгүй</p> <p>18. Тодорхой нэр дэвшигчид санал өгүүлэхийн тулд таныг байнга оршин суудаг хаягаас өөр байршил руу шилжин, сонгуульд оролцохыг санал болгож байсан тохиолдол бий юу?</p> <p>a. Тийм, би санал өгөхийн тулд шилжилт хөдөлгөөн хийж байсан b. Тийм, тэгэхдээ би татгалзсан c. Үгүй, тийм зүйл тохиолдож байгаагүй</p>

Сонгуулийн өдөр	19. Хамгийн сүүлд өгсөн сонгуульд саналаа өгөхөд танд ямар нэгэн саад бэрхшээл учирсан уу? (тайлбарлан бичнэ үү)
	20. Таны саналыг мөнгө болон бусад зүйлээр худалдан авах саналыг тавьж байсан уу? а. Тийм б. Үгүй
Сонгуулийн үр дүн/Дүн шинжилгээ/ Хариуцлага нэхэх	21. Хэрвээ улс төрд биднийг төлөөлөхөөр сонгогдсон эрх мэдэлтний гаргасан шийдвэр танд таалагдахгүй бол та юу хийдэг бэ? а. Юу ч хийдэггүй б. Олон нийтийн сүлжээгээр эсэргүүцлээ илэрхийлдэг с. Холбогдох байгууллагууд руу албан ёсны гомдол мэдүүлдэг д. Олон нийтийн эсэргүүцлийн жагсаал цуглаанд оролцдог е. Өөр аргаар тэмцдэг бол бичнэ үү
	22. Сонгогдсон эрх мэдэлтний өгсөн амлалтууд хэрэгжиж буй эсэхэд та хяналт тавьдаг уу? а. Байнга хянадаг б. Ер нь хянадаг с. Цөөн тохиолдолд хянадаг д. Ерөөсөө хянадаггүй
	23. С болон D хариултыг сонгосон бол та яагаад сонгуулийн амлалтын хэрэгжилтэд хяналт тавьдаггүй вэ?

Хавсралт 2: Ганцаарчилсан ярилцлагын асуулт


I. Төлөөлөл

1. Таны бодлоор, улс төрийн намууд сонгуулийн сурталчилгаандаа эмэгтэйчүүд, залуучуудын хувьд чухал гэгддэг асуудлуудыг хэрхэн тусгадаг вэ?
 - a. Намуудын мөрийн хөтөлбөр, амлалт боловсруулах явцад эмэгтэйчүүд, залуучууд хэрхэн оролцдог вэ?
2. Таны бодлоор, улс төрийн намууд залуучууд, эмэгтэйчүүдийг шийдвэр гаргах түвшний үйл ажиллагаандаа оролцуулах тал дээр хүчин чармайлт гаргаж байна уу? Яаж?
 - a. Эмэгтэйчүүд, залуучуудыг нам доторх нөлөөтэй, өндөр албан тушаалд хэрхэн томилдог вэ? Энэ нь яаж явагддаг вэ?
 - b. Нам доторх нөлөөтэй, өндөр албан тушаалын хэдэн хувийг эмэгтэйчүүд эзэлдэг вэ?
3. Нам дотор идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг эмэгтэйчүүдийн болон залуучуудын холбоод байна уу? Тэдгээр нь намын бусад үйл ажиллагаатай хэрхэн уялдан ажилладаг вэ?
 - a. Намын шийдвэр гаргах явцад эмэгтэйчүүдийн болон залуучуудын холбоод яг яаж нөлөөлж чаддаг вэ?
 - b. Эдгээр холбоод нам дотроо хэр их эрх мэдэлтэй байдаг вэ?
4. Эмэгтэйчүүдэд намын дотоод албан тушаалд өрсөлдөх эрх тэгш хангагдсан уу?
5. Улс төрийн намууд залуучууд, эмэгтэйчүүдийг намаас гадуур албан тушаалд (улс төрийн, захиргааны гэх мэт) томилох, ажиллахыг хэрхэн дэмждэг вэ?
 - a. Намуудын хооронд ялгаа байна уу?
 - b. Эмэгтэйчүүд, залуучуудыг тухайн албан тушаалд томилохын тулд намын хүний нөөцийн бодлогын дагуу, нээлттэй, ил тод төлөвлөгөө гарган ажилладаг уу?
 - c. Намуудад эмэгтэйчүүд, залуучуудыг сонгуульд албан тушаалд нэр дэвшүүлэх квот байдаг уу?
 - d. Нэр дэвшигчдийн жагсаалтыг хэрхэн гаргадаг вэ?
 - e. Намууд нэр дэвшигчдэдээ материаллаг дэмжлэг (санхүүгийн, хүн хүчний) үзүүлдэг үү? Нас, хүйс харгалзахгүй бүх нэр дэвшигчдэд ижил тэнцүү байдаг уу?
 - f. Монгол Улс яагаад өнөөдрийг хүртэл эмэгтэй нийслэл, аймгийн засаг даргагүй байна вэ?
6. Улс төрийн намын удирдлагыг хэрхэн тогтоодог вэ? Намын удирдагч болоход ямар хүчин зүйлс хамгийн их нөлөөлдөг гэж та бодож байна вэ?

II. Нийгэм, хэвлэл мэдээлэл

Үзэл бодлоо хуваалцсан танд баярлалаа. Харин одоо Монголын нийгэм болон хэвлэл мэдээлэлд эмэгтэйчүүд, залуусын сонгуулийн оролцоог хэрхэн хүлээж авдаг тухай ярилцъя.

1. Ерөнхийдөө эмэгтэйчүүд, залуучуудад улс төрийн үйл явцад оролцох боломж, бололцоо хэр байдаг вэ? Жишээ нь:
 - a. Улс төрийн намд элсэх



- б. Улс төрийн албан тушаалд өрсөлдөх
- с. Улс төрийн албан тушаал ахих
- д. Улс төрийн шийдвэр гаргах албан тушаалд томилогдох

2. Эмэгтэйчүүд, залуучууд улс төрийн үйл явцад оролцоход ямар саад, бэрхшээл тулгардаг гэж та боддог вэ?

- а. Саналаа өгөхөд?
- б. Улс төрийн намд элсэхэд?
- с. Сонгуульд өрсөлдөхөд?

3. Сонгуульд саналаа өгч байгаа, сонгуулийн ажилд оролцож байгаа эсвэл сонгуульд нэр дэвшиж байгаа эмэгтэйчүүдийг айлган сүрдүүлж буйг харсан уу? Энэ талаар сонсож байсан уу?

- а. Хэрэв тийм бол энэ нь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоонд хэрхэн нөлөөлж болох вэ?
- б. Эмэгтэйчүүд рүү тусгайлан санаатайгаар халдсан гэж бодож байна уу?

4. Таны бодлоор хэвлэл мэдээллийн хэрэгслүүд улс төрд байгаа эмэгтэйчүүдийг мэдээллийн эрх тэгш байдлаар хангадаг уу?

- а. Яагаад үгүй гэж?

5. Ерөнхийдөө эмэгтэй нэр дэвшигчдийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэрхэн гаргадаг вэ?

- а. Эмэгтэй нэр дэвшигчдийн талаар зусардаж, аль эсвэл таагүй сэтгэгдэл төрүүлэхүйцээр дүрсэлж байсан жишээ байна уу?

6. Шийдвэр гаргах түвшинд байгаа эмэгтэйчүүд, залуучуудын улс төрийн оролцоотой холбоотой саад бэрхшээл, чухал үйл явдлуудыг хэвлэл мэдээллийн хэрэгслүүд хангалттай мэдээлдэг гэж та бодож байна уу?

- а. Яагаад, яагаад үгүй гэж?

7. Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд эмэгтэй улстөрчдийг жендерийн уламжлалт сэтгэлгээгээр дүгнэдэг хандлага ажиглагддаг уу?

III. Сонгуулийн зохион байгуулалт болон хууль, эрхзүйн хүрээ

Хэрэгцээтэй мэдээлэл өгсөн танд баярлалаа. Эцэст нь таниас Монгол улсад эмэгтэйчүүд, залуучуудыг сонгуульд оролцоход нь хууль, эрхзүйн зохицуулалт хэрхэн үйлчилдэг тухай асуумаар байна.

1. Монгол Улсын Үндсэн хууль болон сонгуулийн тухай хуулиудаар хүн амын сонгуулийн оролцоог дэмждэг үү? Өөрөөр хэлбэл холбогдох хуулиудад нас, хүйс хамаарахгүйгээр сонгуулийн үйл явцад оролцох эрх тэгш боломжийг олгож байна уу?

2. Эдгээр хууль эрх зүйн заалтыг дагуу холбогдох оролцогч талууд ойлгож, хэрэгжүүлж, эрхээ эдэлж чаддаг уу?

- а. Энэ нь бүс нутаг, шат шатны байгууллага, хүн ам зүйн хувьд ялгаатай байдаг уу?

3. Сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулахад эмэгтэйчүүд, залуучуудын төлөөллийг оролцуулах талаар хууль, эрх зүйн ямар зохицуулалт байдаг вэ?

- а. Сонгууль зохион байгуулах хорооны бүтэц бүрэлдэхүүнийг хэрхэн тогтоодог вэ? Энэ нь улсын хэмжээнд болон орон нутгийн түвшинд ялгаатай байдаг уу?
- б. Сонгуулийн хэсгийн хороодын хувьд? Санал авах байранд ажиллах хүмүүсийг хэрхэн сонгож авдаг вэ?

IV. Дүгнэлт

Ярилцсанд их баярлалаа. Эмэгтэйчүүд, залуучуудын сонгуулийн үеийн улс төрийн оролцооны талаар нэмж хэлэх зүйл танд байна уу?

Хавсралт 3: Фокус бүлгийн ярилцлагын асуулт

Үйл ажиллагаа, асуулт	Хугацаа, заавар
Яриа эхлүүлэх, танилцуулга (оролцогчдоос хамаарч шаардлагагүй байж болно)	15 минут <ul style="list-style-type: none"> Модераторуудыг танилцуулах Төслийн зорилго, нууцлалыг тайлбарлах Үндсэн дүрэм гаргах Оролцогчид өөрсдийгөө танилцуулах, яриа эхлэх
Сонгуулийн үйл явцын талаар ерөнхий санал дүгнэлт	
<ul style="list-style-type: none"> Ер нь монголын улс төр дэх залуучууд, эмэгтэйчүүдийн талаарх таны бодол? Таны сонгуулийн үйл явцад оролцох боломж, бололцоохэр байдаг вэ? Үүнд саналаа өгөх, нэр дэвших ба бусад Монгол Улсын шат шатны сонгуультай холбоотой бүх зүйлийг багтааж болно. Таны сонгуульд оролцох оролцоо өмнөх жилүүдтэй харьцуулахад өөрчлөгдсөн гэж бодож байна уу? Яагаад, яагаад үгүй гэж? 	20 минут <ul style="list-style-type: none"> Танилцуулга асуулт Бүх оролцогчдыг хэлэлцүүлэгт оролцож асуултад хариулахыг уриалах
Оролцооны хэлбэрүүд	
Таны сонгуулийн үйл явцад ямар байдлаар оролцсон талаар ярилцъя. Мөн Монгол дахь бусад залуучууд, эмэгтэйчүүдийн сонгуулийн оролцооны талаар ярилцацгаая. Эдгээрт саналаа өгөх, сонгуульд нэр дэвших гэх мэт сонгуультай холбоотой юу ч байж болно.	20 минут <ul style="list-style-type: none"> Бүх оролцогчид асуултыг ойлгосон гэдгийг бататгах. Ойлгоогүй тохиолдолд товч тайлбарлаж өгнө үү. Ярилцах эерэг болон сөрөл тохиолдлууд нь заавал өөрт тохиолдсон байх албагүй

	гэдгийг тайлбарлах.
<ul style="list-style-type: none">• Сонгуулийн үйл явцад оролцоход гарсан эерэг эсвэл сөрөг тохиолдлуудын талаар тодорхой жишээ дурдвал?• Үүнд юу нөлөөлсөн гэж бодож байна вэ?	<ul style="list-style-type: none">• Хоёрдугаар асуултад хариулахдаа дэлгэрэнгүй мэдээлэл өгөх шаардлагатай байгаа тул тодруулж асууна уу.